ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 88883776 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 199

танай 2025.01.27-ны № 1/02 -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
16 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ГАНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022064

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 4 зорилт, 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 92.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**45,403,852.90**	**57,879,155.73**
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	39,312,738.53	51,811,594.73
335	**Бусад авлага**	107,577.37	
3351	Байгууллагаас авах авлага	107,577.37	
35	**БАРАА МАТЕРИАЛ**	5,983,537.00	6,067,561.00
351	**Түүхий эд материал**	3,560,211.00	3,007,811.00
35110	**Тусгай зориулалттай материал**	3,313,211.00	3,007,811.00
35130	Эм боох материал	247,000.00	
354	**Хангамжийн материал**	2,423,326.00	3,059,750.00
35420	Аж ахуйн материал	436,526.00	
35460	Хүнсний материал		217,950.00
35470	Бусад хангамжийн материал	1,986,800.00	2,841,800.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**22,988,898.70**	**3,017,398,529.13**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	**22,988,898.70**	**3,017,398,529.13**
392	**Биет хөрөнгө**	22,507,648.70	
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,798,626,925.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,646,923.00	43,144,135.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,292,363.10)	(5,765,753.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,491,530.00	38,701,905.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,423,122.44)	(1,276,275.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,887,022.00	1,121,518,024.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,802,340.76)	(17,350,681.44)
393	**Биет бус хөрөнгө**	**481,250.00**	**40,250,250.00**
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(673,750.00)	(904,750.00)
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**68,392,751.60**	**3,075,277,684.86**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**		**2,991,779.70**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**		2,991,779.70
413	**Өглөг**		2,991,779.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		2,991,779.70
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**68,392,751.60**	**3,072,285,905.16**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	68,392,751.60	68,392,751.60
512	**Хуримтлагдсан үр дүн**	68,392,751.60	68,392,751.60
51210	Өмнөх үеийн үр дүн		68,392,751.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,003,893,153.56
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**68,392,751.60**	**3,075,277,684.86**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**168,217,500.00**	**356,527,814.66**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**		**2,997,666,914.66**
120	**Нийтлэг татварын бус орлого**		**2,996,647,014.66**
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		2,996,647,014.66
122001	Хандив тусламж/дотоод/		1,019,900.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**		**116,447,500.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**		102,147,500.00
131001	**Урсгал үйл ажиллагааны санхүүжилт**		102,147,500.00

131007	**Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих**	168,217,500.00	449,413,400.00
1320	Орон нутгийн төсвөөс сөнхүүжих		14,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/		14,500,000.00
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**172,853,808.03**	**557,914,861.14**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**172,853,808.30**	**557,914,861.14**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	172,853,808.30	556,770,970.38
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	130,010,843.54	426,630,856.67
210101	Үндсэн цалин	90,271,674.13	296,575,398.52
210102	Нэмэгдэл	34,639,581.41	116,496,758.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,099,588.00	13,558,699.54
210104	Урамшуулал	5,099,588.00	13,558,699.54
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**12,866,199.45**	**52,941,425.00**
210201	Тэтгэврийн даатгал	7,923,826.73	36,000,149.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,275,758.28	4,235,294.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	956,480.57	2,117,697.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,733.11	2,117,697.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,456,400.76	8,470,588.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**		**12,356,109.24**
210301	Гэрэл, цахилгаан		5,854,957.99
210302	Түлш, халаалт		3,833,750.25
210303	Цэвэр, бохир ус		2,667,401.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**574,800.00**	**55,583.21**
210401	Бичиг хэрэг	574,800.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		55,583.21
2105	**Норматив зардал**	22,612,038.00	43,724,129.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,612,038.00	43,724,129.20
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**370,000.00**	**555,000.00**
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	370,000.00	555,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**6,419,927.04**	**20,507,867.06**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,560,300.00	11,154,226.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,199,400.00	2,042,140.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,660,227.04	7,311,501.06
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**		**1,143,890.76**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**		1,143,890.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,143,890.76
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**(4,636,308.03)**	**3,005,612,953.52**
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		1,719,799.96
5	**НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)**	**(4,636,308.03)**	**3,003,893,153.56**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**331,459,700.00**	**565,860,900.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**331,459,700.00**	**565,860,900.00**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**		**565,860,900.00**
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / Улсын төсөв/		102,147,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,459,700.00	449,413,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		14,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/		14,500,000.00
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**365,052,430.73**	**553,362,043.80**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**365,052,430.73**	**553,362,043.80**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**365,052,430.73**	**553,362,043.80**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	274,555,585.53	423,531,499.60
210101	Үндсэн цалин	197,812,215.76	293,204,577.39
210102	Нэмэгдэл	64,271,779.53	116,496,758.61
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**34,370,158.20**	**52,941,425.00**
210201	Тэтгэврийн даатгал	23,824,099.00	36,000,149.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,830,440.42	4,235,294.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,182,626.46	2,117,697.00
210204	Ажилгүйдлийн даатгал	510,356.94	2,117,697.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,022,635.38	8,470,588.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**		**12,356,109.24**
210301	Гэрэл, цахилгаан		3,254,957.99
210302	Түлш, халаалт		6,633,750.25
210303	Цэвэр, бохир ус		2,467,401.00
2105	**Норматив зардал**	**41,540,149.00**	**43,942,079.20**
210502	Хоол хүнс	41,540,149.00	43,942,079.20
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**		**1,000,000.00**
210604	Урсгал засвар		1,000,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**670,000.00**	**1,515,000.00**
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	670,000.00	1,515,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**13,916,538.00**	**16,932,040.00**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,586,438.00	11,730,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,330,100.00	5,202,040.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**		**1,143,890.76**
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,143,890.76
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)**	**(33,592,730.73)**	**12,498,856.20**
8	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)**	**(33,592,730.73)**	**12,498,856.20**
9	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**72,905,469.26**	**39,312,738.53**
10	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**39,312,738.53**	**51,811,594.73**

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл			**68,392,751.60**	**68,392,751.60**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			68,392,751.60	68,392,751.60
Тайлант үеийн үр дүн			3,003,893,153.56	3,003,893,153.56
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			**3,072,285,905.16**	**3,072,285,905.16**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	**Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл**		**39,312,738.53**	**-39,312,738.53**
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**813,800.00**	**813,800.00**	**-**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**813,800.00**	**813,800.00**	**-**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**813,800.00**	**813,800.00**	**-**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**590,673,600.00**	**530,924,819.20**	
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**590,673,600.00**	**519,613,179.20**	
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**462,162,800.00**	**421,472,100.00**	**41,822,700.00**
210101	Үндсэн цалин	338,968,800.00	293,204,577.39	45,764,222.61
210102	Нэмэгдэл	123,194,000.00	116,496,758.61	6,697,241.39
210104	Урамшуулал	1,132,000.00	11,770,764.00	-10,638,764.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**54,365,000.00**	**52,684,000.00**	**1,681,000.00**
210201	Тэтгэврийн даатгал	36,969,100.00	35,825,100.00	1,144,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,348,300.00	4,214,700.00	133,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,174,600.00	2,107,400.00	67,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,174,600.00	2,107,400.00	67,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,698,400.00	8,429,400.00	269,000.00
2105	**Норматив зардал**	**50,234,800.00**	**43,942,079.20**	**6,292,720.80**
210502	Хоол хүнс	50,234,800.00	43,942,079.20	**6,292,720.80**
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**1,826,100.00**	**1,515,000.00**	**-1,425,900.00**
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,826,100.00	1,515,000.00	**311,100.00**
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**17,491,100.00**	**11,311,640.00**	**1,351,460.00**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,227,800.00	6,054,600.00	**1,345,200.00**
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,263,300.00	5,257,040.00	**6,260.00**

81835	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,648,000.00	2,316,825.00	**331,175.00**
	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	**2,648,000.00**	**2,316,825.00**	**331,175.00**
	Бараа, үйлчилгээний зардал	2,648,000.00	2,316,825.00	**331,175.00**
	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	**2,353,700.00**	**2,059,400.00**	**294,300.00**
	Урамшуулал	2,353,700.00	2,059,400.00	**294,300.00**
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	**294,300.00**	**257,425.00**	**36,875.00**
	Тэтгэврийн даатгал	200,100.00	175,049.00	**25,051.00**
	Тэтгэмжийн даатгал	23,500.00	20,594.00	**2,906.00**
	ҮОМШӨ-ний даатгал	11,800.00	10,297.00	**1,503.00**
	Ажилгүйдлийн даатгал	11,800.00	10,297.00	**1,503.00**
	Эрүүл мэндийн даатгал	47,100.00	41,188.00	**5,912.00**
	Засгийн газар хоорондын шилжүүлэг	**590,673,600.00**	**538,861,905.27**	
	ЗАРДЛЫН САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**590,673,600.00**	**538,861,905.27**	**51,811,594.73**
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	590,673,600.00	538,861,905.27	
	Улсын төсвөөс санхүүжих	590,673,600.00	538,861,905.27	
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	590,673,600.00	538,861,905.27	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		**39,312,738.53**	**-39,312,738.50**
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		**51,811,594.73**	**-51,811,594.73**

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл			
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**9,400,000.00**	**14,500,000.00**	**-5,100,000.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**9,400,000.00**	**14,500,000.00**	**-5,100,000.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**9,400,000.00**	**13,356,109.24**	**-3,956,109.24**
2103	**БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ**	**9,400,000.00**	**12,356,109.24**	**-2,956,109.24**
210301	Гэрэл, цахилгаан	2,100,000.00	3,254,957.99	-1,154,957.99
21302	Түлш халаалт	5,600,000.00	6,633,750.25	-1,033,750.25
21303	Цэвэр, бохир ус	1,700,000.00	2,467,401.00	-767,401.00
26	**Төвлөрүүлэх шилжүүлэг**		**1,143,890.76**	**-1,143,890.76**
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		**1,143,890.76**	**-1,143,890.76**
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**9,400,000.00**	**14,500,000.00**	**-5,100,000.00**
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,400,000.00	14,500,000.00	-5,100,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40.0 сая төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Газар дансанд бүртгэгдсэн хөрөнгийг биет бус хөрөнгөд шилжүүлж бүртгэж залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 46.5 сая төгрөгийн 2 зөрчил[2] илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв.

2.1 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 100.0 хувиар тооцон 2.5 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тендерээр худалдан авалтын 44.0 сая төгрөгийн гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно, 48 дугаар зүйлийн 48.2.9-д Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газар дансанд бүртгэгдсэн хөрөнгийг биет бус хөрөнгөд шилжүүлж бүртгэж залруулав.	1	40,000,0					1	40,000,0				
Дүн	**1**	**40,000,0**					**1**	**40,000,0**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг олгосон	1	2,513.0			1	2,513.0						
Тендерээр худалдан авалтын гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн	1	44,000.4			1	44,000.4						
Дүн	**2**	**46,513.4**			**2**	**46,513.4**						

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 167/19125799
ДОА-2025/1501 НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчид 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,513,000.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн *15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;* Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 *дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040439

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Гантуяа, нягтлан бодогч Б.Гэрэлчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 168/1912579 9 ДОА-2025/1501 НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах 44,000,400.00 төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ гэрээний үнэ болон нийлүүлэх бараа бүтээгдхүүний мэдээлэл, холбогдох нотлох баримтыг бүрдүүлээгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх" зарчим, 39 дүгээр зүйлийн 39.3-т."Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 39.3.1-д *"гэрээний үнэ"*, 39.3.2-т *"гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл"*, 48 дугаар зүйлийн 48.2.7-т "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", 48.2.9-т "Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах", 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 дэх *"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"*, 4.2.1.11 *дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу хийж, гэрээний биелэлтийг дүгнэж байх , биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2125040440

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Гантуяа, нягтлан бодогч Б.Гэрэлчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СӨМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ